



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/42

Мандалговь

“Хүүхдийн тусламжийн 108 утас”-ыг  
сурталчилан таниулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.1.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2021 оны 5 дугаар сарын 17 буюу “Олон улсын хүүхдийн тусламжийн утасны өдөр”-ийн хүрээнд хүүхдийн тусламжийн 108 утас, Чатбокс үйлчилгээг сурталчлах ажлыг зохион байгуулсугай.
2. Ажлын удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Үйл ажиллагаанд шаардагдах 581700 (Таван зуун наян нэгэн мянга долоон зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн (Б.Цэцэг)-д үүрэг болгосугай.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн (Б.Цэцэг)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

487190085

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын  
хөгжлийн газрын даргын 2021 оны 25 дугаар сарын  
11-ны өдрийн 11/12 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



**“ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН 108 УТАС”, “ЧАТБОКС”  
ҮЙЛЧИЛГЭЭГ СУРТАЛЧИЛАН ТАНИУЛАХ УДИРДАМЖ**

**Зорилго:** Иргэд олон нийтэд Хүүхдийн тусламжийн утас 108, Чатбокс үйлчилгээг сурталчлан, хүүхэд, өсвөр үеийнхэнд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд холбон зуучлахад оршино.

**Хугацаа:** 2021.05.17-ны өдөр

**Хамрах хүрээ:** Дундговь аймгийн 15 сум

**Зохион байгуулагч:** Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар

**Хамтран зохион байгуулагч:** Нийгмийн бодлогын мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан

**Зохион байгуулагдах үйл ажиллагаа:**

| № | Үйл ажиллагаа                                                                                                                                    | Хугацаа                  | Хариуцах албан тушаалтан      |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-------------------------------|
| 1 | Хүүхдийн тусламжийн 108 утас, Чатбокс буюу чатаар сэтгэлзүйн зөвлөгөө авах үйлчилгээг байгууллагын цахим хаягаар сурталчлах                      | 2021.05.17               | Б.Мөнх-Оргил<br>Мэргэжилтнүүд |
| 2 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг Хүүхдийн тусламжийн 108 утас болон байгууллагын пэйж хаягт нэгдүүлэн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх | 2021.05.17<br>2021.05.19 | Б.Цэцэг                       |
| 3 | Байгууллагын гадна самбарт хүүхдийн тусламжийн 108 утас, Чатбокс үйлчилгээний талаарх баннер байршуулах                                          | 2021.05.17               | Б.Цэцэг<br>Жижүүрүүд          |
| 4 | Хүүхдийн тусламжийн 108 утсыг сурталчилсан тараах материал хэвлүүлж иргэдэд түгээх                                                               | 2021.05.17               | Б.Цэцэг                       |
| 5 | Гэр хорооллуудын гудамжны өнцөгт хүүхдийн эрх, хамгааллын талаар постер хийж байршуулах                                                          | 2021.05.18               | Б.Цэцэг<br>Мэргэжилтнүүд      |

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын  
хөгжлийн газрын даргын 2021 оны 45 дугаар сарын  
11. ны өдрийн 11/12 дугаар тушаалын 42 дүгээр хавсралт



“ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН 108 УТАС”, “ЧАТБОКС” ҮЙЛЧИЛГЭЭГ  
СУРТАЛЧИЛАН ТАНИУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

| №           | Шаардагдах материал  | Хэмжих нэгж     | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт          |
|-------------|----------------------|-----------------|------------|-------------|---------------|
| 1           | Үзүүлэн /60см*40см/  | Ш               | 100        | 2500        | 250000        |
| 2           | Тараах материал      | Ш               | 300        | 500         | 150000        |
| 3           | Баннер /4.2*2.0метр/ | Мк <sup>2</sup> | 8.4        | 8000        | 67200         |
| 4           | A4 постер            | Ш               | 50         | 1500        | 75000         |
| 5           | Өнгөт хэвлэл         | Ш               | 17         | 1000        | 17000         |
| 6           | Хадаас               | Кг              | 1          | 4500        | 4500          |
| 7           | Уяа                  | м               | 15         | 1200        | 18000         |
| <b>НИЙТ</b> |                      |                 |            |             | <b>581700</b> |

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР